



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 23 өдөр

Дугаар А/166

Мандалговь

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх "Сайнцагаан сум 1 дүгээр цэцэрлэгийн барилга, 150 ор" ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:	Э.Чагнаадорж (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга)
Гишүүд:	Ц.Бямбацогт (Иргэний төлөөлөл) О.Амарсанаа (Цагдаагийн газрын дарга) Т.Цэнгэлмаа (Сайнцагаан сум 6-р цэцэрлэг арга зүйч)
Нарийн бичгийн дарга:	С.Ууганбаяр (Орон нутгийн өмчийн газрын дарга)

Хоёр. Тендер шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг Үнэлгээний хорооны дарга (Э.Чагнаадорж)-д даалгасугай.

Гурав. Тендер шалгаруулалттай холбогдолтой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (С.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488190458